



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2012 оны 10 сарын 11 өдөр

Дугаар 18/3

Номгон

"Чандмань-Баянхонгор" ХХК-ыг өөрчлөн
байгуулах, шинэчилсэн дүрэм
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн нэгийн 3-ын "е", "ж", 29 дүгээр зүйлийн нэгийн 2-ын "в" заалтуудыг үндэслэн аймгийн ИТХ-ын ээлжит бус XVIII хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. "Чандмань-Баянхонгор" ХХК-ийг хувьцаат компанийн хаалттай хэлбэрээр өөрчлөн байгуулсугай.

Хоёр. "Чандмань-Баянхонгор" ХК-ийн шинэчлэн найруулсан дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

Гурав. Тус компанийн нийт хувьцааны 51 хувийг орон нутгийн өмчинд, 20 хувийг компанийн ажиллагсдад эзэмшүүлж, үлдэх 29 хувийг орон нутгийн иргэдэд худалдах бэлтгэл ажлыг зохион байгуулан аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхийг "Чандмань-Баянхонгор" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл болон аймгийн Орон нутгийн өмчийн албанд даалгасугай.

Дөрөв. Ажиллагсдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх журмын шинэчлэн найруулагдсан дүрэмд нийцүүлэн боловсруулж Төлөөлөн удирдах зөвлөлөөрөө хэлэлцүүлэн батлуулахыг тус компанийн гүйцэтгэх захирал /М.Хосбаяр/-д үүрэг болгосугай.


Тав. Шинэчлэн найруулагдсан дүрмийг мөрдөж ажиллахыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх захирал /М.Хосбаяр/нарт даалгасугай.

ДАРГА

Г.БАТЖАРГАЛ

0112028

**“ЧАНДМАНЬ-БАЯНХОНГОР” ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ДҮРЭМ**
/шинэчилсэн найруулга/



Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү дүрэм нь “Чандмань-Баянхонгор” хувьцаат компанийн эрх зүйн байдал, үйл ажиллагааны чиглэл, компанийн хувьцаа, үнэт цаас болон удирдлагын бүтэц хяналтын тогтолцоо, тэдгээрийн эрх, үүргийг тодорхойлсон эрх зүйн үндсэн баримт бичиг мөн.

1.2 “Чандмань-Баянхонгор” хувьцаат компани /цаашид “компани” гэх/ нь Монгол улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

1.3 Компани нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, банкинд харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг хүлээдэг, өөрийн тусгайлсан эд хөрөнгөтэй, санхүүгийн тайлан гаргадаг, ашгийн төлөө хуулийн этгээд мөн.

1.4 Компанийн оноосон нэр нь “Чандмань-Баянхонгор” хувьцаат компани болно.

1.5 Компанийн байршил нь түүний гүйцэтгэх удирдлагын байрлаж буй хаягаар тодорхойлогдох бөгөөд хаягийн өөрчлөлтийг компанийн гүйцэтгэх удирдлага тухай бүр улсын бүртгэлд бүртгүүлнэ.

1.6 Компани нь өөрийн барааны тэмдэг болон бэлгэдэл /эмблем/-тэй байхаас гадна хууль тогтоомжид заасны дагуу албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр бүхий тэмдэг хэрэглэнэ.

1.7 Бэлгэдэл, барааны тэмдгийн загварыг Төлөөлөн Удирдах Зөвлөл /ТУЗ/-өөс баталж, Оюуны өмчийн газарт бүртгүүлсэн байх бөгөөд тэдгээрийг хэрэглэх эрхийг зөвхөн Компани эдэлнэ.

Хоёр. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

2.1 Компани нь дор дурдсан үндсэн үйл ажиллагааг эрхэлнэ:

2.1.1 Нийтийн аж ахуйн үйлчилгээ

2.1.1.1 Хог хаягдал ялгах, зөөвөрлөх, боловсруулах үйлдвэрлэл, хот тохижилтын үйлчилгээ

2.1.1.2 Суурин газрын ус хангамжийн худаг, ус түгээх цэгийн ашиглалт, засвар үйлчилгээ, зөөврийн ус хангамж



2.1.1.3 1000 м³ / хоног хүртэл хүчин чадалтай ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээ

2.1.1.4 Орон сууцны барилга, байгууламжийн цэвэр, бохир ус, дулаан, цахилгааны шугам сүлжээ, ус дулаан дамжуулах төвийн ашиглалт, засвар үйлчилгээ. Хот суурины ус хангамж ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн заалтын дагуу

2.1.2 Дулаан үйлдвэрлэх, түгээх хангах

2.1.3 Халуун-хүйтэн усны тоолуур суурилуулах, худалдах

2.1.4 Барилга угсралт

2.1.4.1 Мод ба өрөгт бүтээцэн барилгын ажил

2.1.4.2 Барилгын дотор халаалт салхивч, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт

2.1.4.3 Барилгын дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн угсралт, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт

2.1.4.4 Ус хангамж, ариутгах татуургын гол /магистралы/ шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт зэрэг Барилгын тухай хуулийн заалтын дагуу

2.1.5 Байгаль орчны нөхөн сэргээлт

2.1.6 Компанийн хуулиар хориглоогүй бөгөөд орлого, ашигаа нэмэгдүүлэхэд чиглэгдсэн бизнесийн бусад үйл ажиллагаа явуулж болох бөгөөд энэ тухай шийдвэрийг Төлөөлөн Удирдах Зөвлөл гаргана.

2.2 Компани нь тодорхой мэргэжил, тусгай зөвшөөрөл шаардах үйл ажиллагаа явуулах тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрөл авч улсын бүртгэлд бүртгүүлсний дараа тухайн үйл ажиллагааг эрхэлнэ.

2.3 Хуульд заасан эрх бүхий байгууллагын шийдвэрээр өөрчлөн байгуулах, татан буулгахаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд компани нь үйл ажиллагаагаа тасралтгүйгээр явуулна.

2.4 Компани нь салбар, төлөөлөгчийн газрыг өөр газар байгуулан ажиллуулж болох ба энэ тухай асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ.

2.5 Салбар, төлөөлөгчийн газрын удирдлагыг Гүйцэтгэх Захиралын санал болгосноор ТУЗ томилно.

Гурав. КОМПАНИЙН ХУВЬЦАА БОЛОН БУСАД ТӨРЛИЙН ҮНЭТ ЦААС

3.1 Компани нь нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 3922938 ширхэг энгийн хувьцаатай байна.

3.2 Компанийн хувьцааны захиран зарцуулах эрх нь ХЭХ байна. Хувьцааны хяналтын багц болох 51 хувь буюу 2000698 ширхэг хувьцаа нь аймгийн ИТХ, ажилчдад 20 хувь буюу 784588 ширхэг хувьцааг эзэмшүүлж, 29 хувь буюу 1137652 ширхэг хувьцааг нээлттэй арилжина.



3.3 Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу энгийн хувьцаанаас гадна бусад үнэт цаас гаргаж болно. Энэ тухай шийдвэрийг ТУЗ санал болгосноор Хувьцаа эзэмшигчдийн хурлаар гаргана.

3.4 Компанийн хувьцаа нь компанид хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлд оролцсон эрхийг нотлох бөгөөд компанийн аливаа эд хөрөнгийг тусгайлан өмчлөх эрхийг нотлохгүй.



Дөрөв. НОГДОЛ АШИГ

4.1 Ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ТУЗ гаргана. Хэрэв хувиарлахгүй гэсэн шийдвэр гаргасан бол энэ тухайгаа ХЭХ-д танилцуулна.

4.2 Хэрэв ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн тохиолдолд уг шийдвэрт хувьцаа бүрт ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр болон ногдол ашиг төлөх өдөр зэргийг заавал заана.

4.3 Хуваарилсан ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдийн нэр дээр өглөг болгон нягтлан бодох бүртгэлд бичилт хийж, хувьцаа эзэмшигчээс шаардсан тохиолдолд олгоход бэлэн байлгах үүргийг гүйцэтгэх удирдлага хүлээнэ. Хэрэв олгож чадахгүй бол алданги хүлээх ба түүнийг гүйцэтгэх захирал хариуцна.

Тав. КОМПАНИЙН УДИРДЛАГА

5.1 Компанийн удирдлага нь дараах бүтэцтэй байна:

5.1.1 Хувьцаа эзэмшигчдийн Хурал

5.1.2 Төлөөлөн Удирдах Зөвлөл

5.1.3 Гүйцэтгэх удирдлага

Зургаа. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

6.1 ХЭХ-ийн бүрэн эрхийн хүрээний дор дурьдсан асуудлыг компанийн ТУЗ-өөс ирүүлсэн саналыг үндэслэн шийдвэрлэнэ. Үүнд:

6.1.1 Компанийн бусадтай нийлүүлэх, нэгтгэх, хуваах замаар компанийг өөрчлөн байгуулах;

6.1.2 Компанийн хэлбэрийг өөрчлөх;

6.1.3 Компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;

6.1.4 Хувьцааг арилжих болон АХЭХ-ийн хүрээнд ажиллагчид хувьцаа эзэмшүүлэх;

6.1.5 Компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;

6.2 ТУЗ нь ХЭХ-ын бүрэн эрхийн хүрээний асуудлыг шийдвэрлүүлэхээр энэ дүрмийн 6.1.2 ба 6.1.1-д заасан этгээдэд хэдий ч хандаж болно.

6.3 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэх асуудлыг компанийн ТУЗ бэлтгэн боловсруулж санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн (4) сарын дотор ХЭХ-д хүргүүлэн холбогдох шийдвэрийг гаргуулна. Хэрэв энэ үүргээ дээрх хугацаанд хэрэгжүүлээгүй бол ТУЗ-ийн энэ асуудлыг оруулах эрхээс бусад эрх дуусгавар болж гишүүд нь 3 жилийн хугацаанд аливаа компанийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдох эрхгүй болно.

6.4 ХЭХ-ын бүрэн эрхийн хүрээний дор дурьдсан асуудлыг ТУЗ-өөс шийдвэрлүүлэхээр ирүүлсэн саналыг тухай бүрд нь авч үзэж шийдвэр гаргана:

6.5 ТУЗ-ийн гишүүдийг томилох,

6.5.2 Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчилсэн найруулгыг батлах,

6.5.3 Их болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах

Долоо. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

7.1 Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь ТУЗ байна..

7.2 ТУЗ нь 9 (есөн) гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн гуравны нэг нь хараат бус гишүүн байна.

7.3 Компанийн ТУЗ-ийн гишүүдийг ХЭХ-аас томилж, чөлөөлнө. Энэ талаар ХЭХ-аас шийдвэр гаргахдаа зөвхөн ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооноос ирүүлсэн саналыг хэлэлцэн шийдвэр гаргана. Хэрэв ирүүлсэн саналыг шийдвэрлэх бололцоогүй гэж үзвэл дахин шаардлага хангасан хүнийг дэвшүүлэх үүрэг өгөх тухай шийдвэр гаргана.

7.4 ТУЗ-ийн гишүүн дараах шаардлагыг хангасан хувь хүн байна:

7.4.1 Хувь хүний хувьд:

7.4.1.1 Нэр хүнд, чадвар, үнэнч шударга, хариуцлагатай байдал

7.4.1.2 Ажлын зав чөлөө

7.4.1.3 Командаар ажиллах хүсэл, чадвар

7.4.2 Мэргэжлийн хувьд:

7.4.2.1 Санхүү, эдийн засаг

7.4.2.2 Менежмент

7.4.2.3 Хямралын үеийн удирдлага

7.4.2.4 Санхүү, мөнгөний зах зээлийн хэрэгсэл

7.4.2.5 Салбарын чиглэлийн мэргэжил

7.4.3 Дадлагажсан чадварын хувьд :

7.4.3.1 Компанийн засаглал ба эрх зүй

7.4.3.2 Бизнес төлөвлөгөө

7.4.3.3 ОУНББС-ийн дагуу гаргасан тайлан балансыг уншиж шинжилгээ хийх

7.4.3.4 Хөрөнгө оруулалтын үндэс

7.4.3.5 Татварын тогтолцоо

7.4.3.6 Санхүүгийн зүй бус ажиллагаа, алдааг илрүүлэх

7.5 ТУЗ-ийн хараат бус гишүүн нь дээрх шаардлагаас гадна дараах шаардлагыг хангасан этгээд байна.

7.5.1 Өөрөө эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшдэггүй .

7.5.2 Компанийн болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид эрх бүхий албан тушаал эрхэлдэггүй.

7.5.3 Төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн болон Улс төрийн /намын харъяалалгүй/ алба хашдаггүй

7.5.4 Компанитай бизнесийн аливаа холбоогүй.

7.6 ТУЗ-ийн нийт гишүүдийн тооноос хараат бус гишүүний тоог хасаад үлдсэн гишүүд нь эзэмшиж буй хувьцааны эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч этгээд байна.

7.7 Аймгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг төлөөлөн хэрэгжүүлэгч нь аймаг дахь төрийн захиргааны албан хаагч байх ба түүнийг аймгийн Засаг даргын саналыг үндэслэн нэр дэвшүүлэх хороо санал болгоно.

7.8 ТУЗ-ийн гишүүдэд олгох цалин урамшууллын хэмжээг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтооно.

7.9 ТУЗ-ийн гишүүдийн урамшуулал нь дараах хэлбэртэй байж болно.

7.9.1 ТУЗ-ийн хуралд оролцсон тохиолдолд олгох урамшуулал

7.9.2 Хорооны ажилд оролцсоны төлөө олгох нэмэгдэл

7.9.3 Хорооны болон ТУЗ-ийн даргын ажлыг гүйцэтгэсний төлөө олгох нэмэгдэл

7.10 ТУЗ нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.10.1 Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, стратеги бодлого түүний дотор компанийн алсын хараа, үнэ цэнэ зэргийг тодорхойлох;

7.10.2 Компанийн бизнес төлөвлөгөөг батлах, түүний гүйцэтгэлд хяналт тавих;

7.10.3 Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тоо, удирдлагын зардлын дээд хязгаарыг батлах;

7.10.4 ХЭХ-ийн бүрэн эрхийн асуудлыг холбогдох этгээдэд оруулж шийдвэрлүүлэх;

7.10.5 Компанийн зарласан хувьцааны тоо, хэмжээнд багтаан хувьцаа гаргах асуудлыг холбогдох байгууллагын зөвшөөрлийг авч шийдвэрлэх;

7.10.6 Компанийн энгийн хувьцаанаас бусад үнэт цаас гаргах;

7.10.7 Компанийн гаргасан хувьцаа, бусад үнэт цаасыг худалдан авах, эргүүлэн авах шийдвэр гаргах;

7.10.8 Компанийн гүйцэтгэх удирдлагыг нэр дэвшүүлэх хорооноос ирүүлсэн саналыг хэлэлцэн томилох, түүний бүрэн эрхийг тогтоох;

7.10.9 Компанийн гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох цалин, шагнал урамшуулал, өмч хөрөнгийг захиран зарцуулах эрх, хариуцлагын хэмжээг тогтоох, гэрээ байгуулах;

7.10.10 Компанийн аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох, компанийн тайлан тэнцэлд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг хэлэлцэж шийдвэр гаргах;

7.10.11 Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах;

7.10.12 Компаниас олгох ногдол ашгийн хэмжээ болон түүнийг төлөх журам, хугацааг тодорхойлох;

7.10.13 ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын чиглэлийн дүрэм, журмыг батлах;



- 7.10.14 Компанийн эрсдэлийн бодлогыг батлах ба түүний гүйцэтгэлд хяналт тавих
- 7.10.15 Компанийн шинээр худалдаж авах болон акталж устгах, худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгөтэй холбогдох асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх;
- 7.10.16 Компанийн салбар, төлөөлөгчийн газар байгуулах;
- 7.10.17 Хууль тогтоомжийн дагуу их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах
- 7.10.18 Дотоод хянан шалгагчийг томилж, ажиллах журмыг батлах
- 7.11 ТУЗ-ийн хурал нийт гишүүдийн дийлэнх олонх /50-с дээш хувь/ нь оролцсоноор хүчин төгөлдөр болно.
- 7.12 ТУЗ-ийн даргыг ТУЗ-ийн нийт гишүүдийн олонхын саналаар сонгоно.
- 7.13 ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, шийдвэр гаргах, хяналт тавих үүргийг хүлээнэ.
- 7.14 ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд хуралд оролцсон төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд өөрийн хэлсэн үг, гаргасан саналын үнэн зөвийг хянан гарын үсэг зурна.
- 7.15 ТУЗ-ийн хурлын шийдвэр нь тогтоол байх ба түүнд ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж, компанийн тэмдгийг дарснаар хүчин төгөлдөр болно.
- 7.16 ТУЗ-ийн даргыг түр эзгүйд түүний үүргийг ТУЗ-ийн даргын, эсхүл ТУЗ-ийн тухайн хурлаас томилсон гишүүн гүйцэтгэнэ.
- 7.17 ТУЗ-ийн хурлыг улиралд нэг удаа хуралдуулах ба шаардлагатай гэж үзвэл нэмэлт хуралдаан хийж болно.
- 7.18 ТУЗ-ийн хурлын шийдвэр нь хуралд оролцож байгаа гишүүдийн дийлэнх олонхын саналаар хүчин төгөлдөр болно.
- 7.19 ТУЗ-ийн хурлыг зарлах, хуралдуулах, хурал хүчинтэй байх, гишүүдийн хуралд оролцох, асуудлыг хэлэлцэх, хурлын дэгийг тогтоох, ТУЗ-ийн даргын эрх болон бусад холбогдох асуудлыг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулна.
- 7.20 ТУЗ нь аудитын, цалин, урамшууллын, нэр дэвшүүлэх хороотой байна.
- 7.21 Хороод өөрсдийн хариуцсан үйл ажиллагааны чиглэлээр дүгнэлт гаргаж ТУЗ-ийн хуралд хэлэлцүүлэн шийдвэр гаргуулах үүрэгтэй.
- 7.22 Хороодын өөрсдийн ажиллах журамтай байх ба түүнийг ТУЗ батална.
- 7.23 ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг ТУЗ-ийн хурлаас зөвлөлийн даргын санал болгосноор томилно.
- 7.24 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь компанийн эрх бүхий албан тушаалтан байх ба Компанийн тухай хуулийн 82 дугаар зүйлд заасны дагуу ажиллах бөгөөд шаардлагатай бол нэмэлт үүргийг ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд тусгаж болно.

7.25 ТУЗ нь гүйцэтгэх удирдлагатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийг цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороодын ирүүлсэн саналыг үндэслэн хэлэлцэж, дүгнэлт өгч зохих шийдвэр гаргана.

7.26 ТУЗ нь жилд нэгээс доошгүй удаа аймгийн Засаг даргад ажлаа тайлагнана.

Найм. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

8.1 Компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал (ГЗ) хэрэгжүүлнэ.

8.2 Гүйцэтгэх захирал нь компанийн дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

8.3 Гүйцэтгэх захирлыг нэр дэвшүүлэх хорооны саналын дагуу түүнтэй байгуулах гэрээг үндэслэн нэр дэвшүүлэх хорооноос ирүүлсэн саналыг хэлэлцэн ТУЗ томилно.

8.4 Гүйцэтгэх захирал нь ТУЗ-тэй байгуулсан гэрээний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна. Гэрээнд ТУЗ-ийг төлөөлж түүний дарга гарын үсэг зурна.

8.5 Гэрээнд гүйцэтгэх захирлын эрх, үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, цалин, урамшуулал, ажлын нөхцөл зэрэг асуудлыг тусгасан байна.

8.6 Гүйцэтгэх захирал нь ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

8.7 Гүйцэтгэх Захирал нь гэрээний биелэлтийг хагас, бүтэн жилээр гаргаж дүгнүүлнэ.

8.8 Гүйцэтгэх захирал нь дараах шалгуурыг хангасан байна.

8.8.1 Менежментийн ур чадвартай, 2-оос доошгүй жил удирдах ажил гүйцэтгэж байсан дадлага туршлагатай, дээд боловсролтой байх;

8.8.2 Зээл буюу батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй байх;

8.8.3 Ял шийтгэлгүй байх;

8.8.4 Ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь компанийг удирдахад харшлахгүй байх.

8.9 Өдөр тутмын болон шуурхай үйл ажиллагааны талаар Гүйцэтгэх захиралд зөвлөх эрх бүхий Захирлын зөвлөлийг ажиллуулж болно. Захирлын зөвлөлийн ажиллах журмыг Гүйцэтгэх захирал батална.

8.10 Гүйцэтгэх захирал дор дурдсан үүрэг хүлээж, эрх эдэлнэ.

8.10.1 ТУЗ-ийн өмнө Компанийн үйл ажиллагааг бүрэн хариуцаж, жилд хоёроос доошгүй удаа ажлын үр дүн, гэрээний үүргийн биелэлтийг тайлагнан дүгнүүлэх;



8.10.2 Компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан тэнцлийг цаг тухайд нь гаргаж, холбогдох этгээдүүдэд тайлагнаж мэдээлэх, түүний үнэн зөвийг хариуцах;

8.10.3 Компанийн үйл ажиллагааны тухайн жилийн зорилтот түвшин, бизнесийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж, ТУЗ-д танилцуулан батлуулах;

8.10.4 Энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомж, норм норматив, компанийн ТУЗ-ийн шийдвэрийг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах;

8.10.5 Гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэх, удирдаж буй компанийн санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах;

8.10.6 Компанийн үзүүлж буй ажил үйлчилгээний үнэ, тарифийг хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд тогтоон мөрдүүлэх

8.10.7 Компанийн эрх ашгийг дээдлэн, мэргэжил, ажлын дадлага, туршлагаа бүрэн дайчлан компанийг удирдах;

8.10.8 Гүйцэтгэх захирлын эрх, үүргийг хэрэгжүүлэх явцад олж авсан мэдээллийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхлоор ашиглахгүй байх;

8.10.9 ТУЗ-өөс баталсан орон тоо, зохион байгуулалтын бүтцийн хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажлаас чөлөөлөх;

8.10.10 Компанийн шинээр худалдан авах болон акталж устгах, худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгийн асуудлыг ТУЗ-ийн хуралд танилцуулан шийдвэрлүүлэх;

8.10.11 Компанийн үйл ажиллагаатай холбогдох асуудлаар тушаал гаргаж, биелэлтийг хангуулах;

8.10.12 ТУЗ-ийн зөвшөөрлийн үндсэн дээр зарим эрх, үүргээ итгэмжлэл гарган компанийн холбогдох албан тушаалтанд шилжүүлж болно. Ийнхүү эрхээ итгэмжлэн шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

Ес. КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

9.1 Компанийн ТУЗ-ийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирал, ерөнхий инженер, ерөнхий нягтлан бодогч, хэсгийн дарга, ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.

9.2 Компанийн эрх бүхий албан тушаалтан нь компанийн дүрэм, ТУЗ-ийн баталсан дотоод журамд заасан үүргийг биелүүлж, компанийн ашиг сонирхлын төлөө үнэнч шударгаар ажиллана.

9.3 Компанийн ТУЗ-ийн дарга, гишүүдээс бусад эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэх хариуцлага, түүний хэмжээг тогтоох асуудлыг ТУЗ-тэй байгуулсан гэрээ, компанийн хөдөлмөрийн дотоод журмаар тогтоох бөгөөд тэдгээрийн дагуу шийдвэрлэх боломжгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

9.4 Компанийн эрх бүхий албан тушаалтан Компанийн тухай хуулийн 84, 85 дугаар зүйлд зааснаар үүрэг, хариуцлага хүлээнэ.

9.5 Компанийн эрх бүхий албан тушаалтан нь өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн талаарх мэдээллийг компанид өгөх үүрэгтэй.

Арав. КОМПАНИЙН ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

10.1 Компанийн хяналтын тогтолцоо нь дараах бүтэцтэй байна.

10.1.1 Өмчлөгчийн хяналт;

10.1.2 Дотоод хяналт;

10.1.3 Хөндлөнгийн аудит.

10.2 Өмчлөгчийн хяналтыг ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо хэрэгжүүлнэ.

10.3 Аудитын хороо 3 гишүүнтэй байх бөгөөд гишүүдийг ТУЗ-өөс томилно.

10.4 Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байна.

10.5 Компанийн Аудитын хорооны ажиллах журмыг ТУЗ батална.

10.6 Аудитын хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулна.

10.6.1 Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;

10.6.2 Дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин, урамшууллыг тогтоох санал боловсруулах;

10.6.3 Аудитын байгууллагыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах;

10.6.4 Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх ажиллагаанд хяналт тавих, дүгнэлт гаргах;

10.6.5 ХЭХ-ын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч, ТУЗ- болон Гүйцэтгэх захирлын гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих,

10.6.6 Компанийн удирдлагын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах

10.7 Компанийн дотоод хяналтыг ТУЗ-ийн томилсон дотоод хянан шалгагч хэрэгжүүлнэ.

10.8 Дотоод хянан шалгагч компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд өдөр тутмын хяналтыг тавьж, гүйцэтгэл нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, энэхүү дүрэм, хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолд нийцэж байгаа эсэхийг хангаж ажиллана.

10.9 Дотоодын хянан шалгагч нь шалгалтаар илэрсэн алдаа, зөрчил, дутагдлыг арилгах, компанийн хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэгдсэн зөвлөмжийг гүйцэтгэх удирдлагад өгөх, ТУЗ-д танилцуулах, мэдээлэх үүрэгтэй.



10.10 Компанийн хөндлөнгийн аудитыг ТУЗ-өөс сонгосон мэргэшсэн аудитын байгууллага гүйцэтгэнэ.

10.11 Хөндлөнгийн аудитын тайланг ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж, дүгнэлт гаргана.

Арван нэг. ИХ ХЭМЖЭЭНИЙ БОЛОН СОНИРХОЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ



11.1 Их хэмжээний хэлцэл гэж тухайн хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хөөрөндөө шууд холбоотой хэд хэдэн хэлцлийг хэлэх бөгөөд түүнийг Компанийн тухай хуулийн 87,88 дугаар зүйлд заасан журмын дагуу хийнэ.

11.2 Сонирхлын зөрчилтэй хэлцэл гэж эрх бүхий албан тушаалтан болон тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн компанитай хийж байгаа аливаа хэлцлийг хэлэх бөгөөд түүнийг Компанийн тухай хуулийн 89, 91, 92 дугаар зүйлд заасан журмын дагуу хийнэ.

11.3 Компани нь тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн дээр дурьдсан гэрээ хэлцэл, түүний үнэ зэргийг улирал, жилийн тайлангийн тодруулгад тусгах замаар нийтэд мэдээлэх үүрэгтэй.

Арван хоёр. КОМПАНИЙН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ТАЙЛАН

12.1 Компани нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн, санхүүгийн тайлан гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулан Хувьцаа эзэмшигч болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна. Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг компанийн Гүйцэтгэх захирал хариуцна.

12.2 Компанийн ерөнхий нягтлан бодогч нь мэргэшсэн нягтлан бодогч байх бөгөөд түүнийг гүйцэтгэх захирал томилж, чөлөөлнө.

12.3 Компани нь хөндлөнгийн аудиторын дүгнэлт гаргуулсны дараа холбогдох хууль тогтоомжид заасны дагуу жилийн санхүүгийн тайлан, ашиг ба алдагдлын тайлангаа компанийн Хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудад танилцуулна.

12.4 Компанийн санхүүгийн жилийн эхлэх хугацааг тухайн оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс, (эсхүл эхний жил бол байгуулагдсан өдрөөс) дуусах хугацааг мөн оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр (эсхүл сүүлчийн санхүүгийн тайлант жил бол Компани нь татан буугдсан өдрийн байдлаар) тогтооно.

Арван гурав. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

13.1 Компани нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу санхүүгийн тайланг НББОУС-ын дагуу гаргах ба түүнд дараах зүйлийг тусгана:

13.1.1.Баланс;

13.1.2.Орлогын тайлан;

13.1.3.Мөнгөн гүйлгээний тайлан;

13.1.4.Өмчийн өөрчлөлтийн тайлан;

- 13.1.5. Хуримтлагдсан ашгийн тайлан;
13.1.6. Нэмэлт тайлбар, тодруулга;
13.1.7. Тухайн тайлангийн хугацаанд байгуулсан их болон сонирхлын зөрчил бүхий хэлцлийн жагсаалт, нэр, төрөл, үнийн дүнгийн хамт;
13.1.8. Тухайн хугацаанд удирдлагад олгосон цалин, урамшил;
13.1.9. Тайлант хугацааны үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайлан;
13.2. Компани нь ХЭ-ийн бүртгэлийг хөтлөх үүрэгтэй



Арван дөрөв. КОМПАНИЙН БИЧИГ БАРИМТЫГ ХАДГАЛАХ

- 14.1 Компанийн бичиг баримтыг хадгалахад компанийн "Архивт баримт хүлээлгэн өгөх журам"-г мөрдөн ажиллана
- 14.2 Компани нь дараах бичиг баримтыг хадгалах үүрэгтэй:
- 14.2.1. Компанийн дүрэм, дүрэмд орсон нэмэлт өөрчлөлт, компанийг байгуулах тухай үүсгэн байгуулагчдын хурлын шийдвэр, компанийн бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөл, лицензүүд
- 14.2.2. Төлөөлөн Удирдах Зөвлөл, Гүйцэтгэх удирдлагаас баталсан компанийн дотоод баримт бичиг;
- 14.2.3. Компанийн салбар болон төлөөлөгчийн газрын дүрэм;
- 14.2.4. Нягтлан бодох бүртгэлд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох баримт бичиг; бодлогын баримт бичиг
- 14.2.5. ХЭХ-ын бүрэн эрхийг хэрэгжүүлэгчийн гаргасан шийдвэр Төлөөлөн Удирдах Зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагын зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэр, тогтоол, Компанийн гүйцэтгэх захирлын тушаал, байгуулсан гэрээ түүний биелэлттэй холбогдох баримт бичиг;
- 14.2.6. Аудитын дүгнэлт;
- 14.2.7. Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан;
- 14.2.8. Хувьцаа болон үнэт цаас гаргах журам;
- 14.2.9. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн бичиг баримт;
- 14.2.10. Компанийн нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн нэрсийн жагсаалт болон тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааны төрөл, тоо;
- 14.2.11. ХЭ-ийн бүртгэл
- 14.2.12. Зурган хэлбэрийн альбом, бичлэг хальс /1 жил хадгалаад архивт шилжүүлнэ/
- 14.2.13. Бусад баримт бичгүүд.
- 14.3 Компани нь баримт бичгийг өөрийн үйл ажиллагаа эрхлэн явуулах газарт стандартын архивын өрөөнд хадгална.
- 14.4 Компани нь өөрийн дүрэм, түүний нэмэлт, өөрчлөлтийг байнга хадгална. Бусад баримт бичгийг 5 жилийн хугацаатайгаар хадгалах бөгөөд хугацаа дууссаны дараа архивт шилжүүлнэ.
- 14.5 ТУЗ, компанийн хувьцаа болон үнэт цаас гаргах, компанийн дүрэм, түүний нэмэлт, өөрчлөлт зэрэгтэй холбогдол бүхий баримт бичгийг хүлээн авах, хадгалах, танилцуулах, архивт шилжүүлэх ажиллагааг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга эрхлэн гүйцэтгэнэ.
- 14.6 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн дотоод үйл ажиллагааг биечлэн хариуцна.

14.7 Компанийн талаарх мэдээлэл, компанийн нэгдмэл сонирхолтой этгээд түүнтэй холбогдох мэдээлэл авах асуудлыг Компанийн тухай хуулийн 98, 99 дүгээр зүйлийн дагуу зохицуулна.

Арван тав. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

15.1 Компанийн энгийн хувьцааг эзэмшсэн этгээд компанийн хувьцаа эзэмшигч байна.

15.2 Энгийн хувьцаа эзэмшигч нь дараах эрх эдэлнэ:

15.2.1 Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах үед ТУЗ-өөс тогтоосон “бүртгэлийн өдөр” компанийн хувьцааг эзэмшиж байсан этгээд хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хэлэлцэж буй бүх асуудлаар өөрийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцаатай хувь тэнцүүлэн санал өгөх

15.2.2 ТУЗ-өөс ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн үед давуу эрхийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилсны дараа эзэмшиж буй хувьцаанд ногдох ногдол ашиг авах, ногдол ашиг олгохоор зарласан боловч хууль, журамд заасан хугацаандаа компанийн буруутай үйл ажиллагаанаас болж олгохгүй бол алданги төлөхийг шаардах

15.2.3 Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуульд заасан журмын дагуу өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос эзэмшиж буй хувьцаанд ногдох хувь хэмжээгээр хувь хүртэх

15.2.4 Компаниас нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэргүүн ээлжид худалдан авах.

15.3 Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар доорх асуудлаар шийдвэр гаргахад эсрэг саналтай байсан, эсвэл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч бүр өөрийн эзэмшиж буй хувьцааг компанид эргүүлэн авахыг шаардах эрхтэй.

15.3.1 Нийлэх, нэгдэх, хуваах болон хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх:

15.3.2 их хэмжээний хэлцэл хийх:

15.3.3 Компанийн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарласан нэмэлт өөрчлөлтийг оруулсан эсвэл ийм агуулгатай компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах:

15.4 Хувьцаа эзэмшигч дангаараа эсвэл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт компанийн энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмших тохиолдолд бусад хувьцаа эзэмшигчид нь компанид хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрхтэй. Эргүүлэн авах хувьцааны үнийг хөрөнгийн биржийн арилжааны сүүлийн 6 сарын дундаж ханшийг үндэслэн ТУЗ тогтооно. Тэгэхдээ Компанийн тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэл болгоно.

15.5 Энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч нь ээлжит хурал хуралдахаас ажлын 45 ба түүнээс дээш хоногийн өмнө хурлаар хэлэлцэх асуудлын талаар нэмэлт санал гаргах, компанийн ТУЗ, эсхүл Гүйцэтгэх удирдлагад нэр дэвшүүлэх эрхтэй.

15.6 Компанийн нийт гаргасан хувьцааны 5-аас дээш хувийг дангаараа болон бусадтай хамтран эзэмшсэн этгээд өмчлөх эрх үүссэнээс хойш 30 хоногийн дотор компанид бичгээр мэдэгдэх үүрэгтэй. Ийнхүү мэдэгдэл ирүүлэх нь компанийн

хувьцаа эзэмшигчдийн хуралд асуудал хэлэлцүүлэхээр оруулах тухай энэ дүрмийн 7.8-д заасан эрхээ эдлэх баталгаа болно.

15.7 Компани хувьцаа эзэмшигчдийн өмнөөс хариуцлага хүлээхгүй.

15.8 Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

15.9 хувьцаа эзэмшигч нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас компанид учруулсан эд хөрөнгийн хохирлыг өөрийн хөрөнгөөр компанийн өмнө хариуцна.

15.10 Хувьцаа эзэмшигчдийн хувийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх компанийн хөрөнгөөс тодорхой зааглагдаагүй бол уг хувьцаа эзэмшигч өөрийн бүх эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээр компанийн өр төлбөрийг давхар хариуцна.

15.11 ХЭ нь компани дээрх ХЭ-ийн бүртгэлд бүртгүүлснээр дээр дурьдсан эрх хэрэгжих хууль зүйн үндэс бүрэлдэнэ.

15.12. ХЭ-ийн бүртгэлд үнэт цаас эзэмшигчийн овог, эцэг, эхийн нэр, оршин суугаа хаяг, үнэт цаасны төрөл, хэмжээ, шилжүүлсэн үнэт цаасны тоо, шилжүүлсэн болон шилжүүлэн авсан этгээдийн овог, эцэг, эхийн нэр, өөрийн нэр зэргийг тусгана

15.13. ХЭ нь энэхүү бүртгэлд тусгагдсан мэдээлэлд орсон нэмэлт, өөрчлөлтүүдийг тухай бүрд бүртгэл хөтлөх этгээдэд мэдэгдэх үүрэгтэй.

Арван зургаа. КОМПАНИЙГ ТАТАН БУУЛГАХ

16.1 Компанийг Иргэний хууль болон бусад холбогдох хуульд заасан үндэслэлээр эрх бүхий байгууллагын шийдвэрээр татан буулгана.

16.2 Татан буулгах комисс томилогдсоноор Компанийн гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх дуусгавар болж, татан буулгах комисст шилжинэ.

Арван долоо. БУСАД ЗААЛТУУД

17.1 Энэ дүрэмд тусгагдаагүй бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

17.2 Энэхүү дүрэм болон түүнд орсон нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болох бөгөөд үндсэн эхийг компани дээр хадгална.

.....оОо.....